



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА  
Э.ТҮВШИНЧУЛУУН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcog@naac.mn, Вэб сайт: http://naac.mn

20220831 № 05/1110  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Басбаярын Болор-Эрдэнэ, Үнэ, тарифын газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Базарваанийн Эрдэнэбулган, Хэрэглэгч, орон нутаг, хяналтын газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Дэрийлаагийн Бат-Эрдэнэ, Захиргаа, удирдлагын газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Абиланы Айдос нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч А.Айдос нь хүнсний дэлгүүр, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "ЕЛЖЕР трейд" ХХК-ийн захирлаар бүртгэлтэй байх тул "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Т.ЭНХБОЛД

УХАД422 5120829